



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2017 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 155

Номгон

Эзэмшигч тогтоох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3а,в, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 3, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит төсвийн байгууллага болон төсөвт үйлдвэрийн газар эд хөрөнгө олж авах, бүртгэх, дуудлагаар худалдах, шилжүүлэх, актлах журам”-ын 1.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 600 метрийн урттай 135,0 сая төгрөгийн өртөг бүхий Баянхонгор сумын 3 дугаар багийн "Багийн хөгжлийн төв"-ийн гадна дулаан, цэвэр бохир усны шугам сүлжээний эзэмшигчийг хавсралтад зааснаар тогтоосугай.

2. Эзэмшигч тогтоосон хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэж, хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ч.Мөнхцэцэг/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

0117123

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 12 дугаар сарын
19-ний өдрийн 155 дугаар тогтоолын хавсралт



БАЯНХОНГОР СУМЫН 3 ДУГААР БАГИЙН "БАГИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ"-ИЙН ГАДНА
ДУЛААН, ЦЭВЭР БОХИР УСНЫ ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ЭЗЭМШИГЧ ТОГТООСОН ЖАГСААЛТ

№	Хэрэгжүүлсэн төслийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Гэрээний дүн /мян.төг/	Бүртгэлд тусгах дүн /мян.төг/	Хөрөнгийн эх үүсвэр	Гүйцэтгэгч байгууллагын нэр	Улсын комисс хүлээн авсан эсэх	Эзэмшигч байгууллага	Тайлбар
1	Баянхонгор сумын 3 дугаар багийн "Багийн хөгжлийн төв"-ийг холбосон инженерийн шугам сүлжээнд холбосон	м	600	135000000	135000000	Орон нутгийн хөгжлийн сан	Халзан хайрхан ХХК	2017.11.27-ны өдөр хүлээн авсан	Аймгийн Биеийн тамир, спортын газар	Дуурсах 3 дугаар багийн төвийн барилгаас Хонгор сургуулийн худаг руу цэвэр усны шугам, дулааны шугам татсан. Дулааныг эмнэлгийн уурын зуухнаас авсан. Алуу дэлгүүрийн хойд талын хашаан дотор худаг нь байдаг. Бохирын шугамыг 2 давхар барилгын зүүн талд байдаг худагтай холбосон. 3-р баг ашиглаад 3 жил гаран болж байгаа боловч улсын комисс хүлээж аваагүй байсан. Энэ хугацаанд ямар нэгэн зөрчил гараагүй шугам сүлжээ хэвийн ажиллаж байгаа. Комисс 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр хүлээн авсан.
				135000000	135000000					
Нийт дүн										